

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/321/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/164  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙБАЯР ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 100 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

019020315



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>212,983,652.30</b>	<b>382,307,470.81</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>47,428,326.49</b>	<b>202,758,161.70</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>47,428,326.49</b>	<b>202,758,161.70</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>47,428,326.49</b>	<b>202,758,161.70</b>
31211	Төрийн сангийн харилцах	47,428,326.49	202,758,161.70
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>360,000.00</b>	<b>0.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>360,000.00</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	360,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>165,195,325.81</b>	<b>179,549,309.11</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>681,390.00</b>	<b>681,390.00</b>
35130	Эм боох материал	681,390.00	681,390.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>156,463,935.81</b>	<b>171,167,919.11</b>
35410	Бичиг хэргийн материал	132,050.00	38,500.00
35420	Аж ахуйн материал	2,888,070.00	2,979,220.00
35450	Барилгын засварын материал	890,000.00	890,000.00
35460	Хүнсний материал	1,873,105.00	2,648,270.00
35470	Бусад хангамжийн материал	150,680,710.81	164,611,929.11
35600	Мал амьтад	8,050,000.00	7,700,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,822,815,372.38</b>	<b>1,980,433,309.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,822,815,372.38</b>	<b>1,980,433,309.21</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,788,126,572.38</b>	<b>1,945,156,509.23</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,656,864,615.00	1,714,117,998.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-107,902,622.29	-135,517,032.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,500,000.00	5,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,500,000.00	-5,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	238,815,039.00	283,826,713.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-140,391,075.75	-83,261,013.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,157,422.80	181,738,871.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-103,282,566.95	-83,044,952.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	117,087,254.00	105,668,654.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-75,305,494.43	-51,500,729.82
39217	Ном	13,084,001.00	13,128,001.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>34,688,800.00</b>	<b>35,276,799.98</b>
39301	Програм хангамж	1,120,000.00	784,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,120,000.00	-196,000.02
39303	Бусад биет бус хөрөнгө	34,688,800.00	34,688,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,035,799,024.68</b>	<b>2,362,740,780.02</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,106,000.00</b>	<b>27,224,315.24</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,106,000.00</b>	<b>27,224,315.24</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>1,106,000.00</b>	<b>27,224,315.24</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	27,224,315.24
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,106,000.00</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,106,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,034,693,024.68</b>	<b>2,335,516,464.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,034,693,024.68</b>	<b>2,335,516,464.78</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	549,958,766.20	549,958,766.20
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	549,958,766.20	549,958,766.20
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>101,587,857.22</b>	<b>402,411,297.32</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,933,105,167.46	101,587,857.22
51220	Тайлант үеийн үр дүн	2,034,693,024.68	300,823,440.10
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,383,146,401.26	1,383,146,401.26
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,035,799,024.68</b>	<b>2,362,740,780.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,710,174,010.29</b>	<b>2,171,834,163.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,012,361,610.29</b>	<b>235,829,963.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,012,361,610.29</b>	<b>235,829,963.30</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>7,412,748.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,532,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,880,648.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,843,193,440.48	222,946,627.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	169,168,169.81	5,470,588.30
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,697,812,400.00</b>	<b>1,936,004,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,356,592,400.00</b>	<b>1,772,981,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,356,592,400.00	1,772,981,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>136,353,900.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,353,900.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>204,866,100.00</b>	<b>163,022,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,866,100.00	163,022,300.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,675,480,985.61</b>	<b>1,874,170,723.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,675,480,985.61</b>	<b>1,874,170,723.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,455,361,823.09</b>	<b>1,770,475,523.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>985,586,672.38</b>	<b>1,156,454,912.52</b>
210101	Үндсэн цалин	654,651,625.12	795,910,485.43
210102	Нэмэгдэл	252,550,172.12	342,663,569.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,182,000.00	4,636,000.00
210104	Урамшуулал	59,202,875.14	13,244,857.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>124,003,976.61</b>	<b>144,709,400.77</b>
210201	Тэтгэврийн даатгал	85,623,134.99	101,105,493.41
210202	Тэтгэмжийн даатгал	10,081,933.84	10,457,772.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,917,706.88	10,709,443.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,852,836.49	1,950,548.66
210205	Эрүүл мэндийн даатгал	18,528,364.41	20,486,142.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>139,936,041.00</b>	<b>180,946,615.24</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,341,960.00	14,845,927.24
210302	Түлш, халаалт	128,594,081.00	166,100,688.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>3,535,850.00</b>
210401	Бичиг хэрэг	0.00	925,350.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	2,610,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>76,761,117.00</b>	<b>100,650,098.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	230,000.00
210502	Хоол, хүнс	76,761,117.00	100,420,098.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,855,000.00</b>	<b>7,330,500.00</b>
210604	Урсгал засвар	13,855,000.00	7,330,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>2,444,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	2,444,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,162,900.00</b>	<b>9,930,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	604,800.00	1,844,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,558,100.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	8,085,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>106,056,116.10</b>	<b>164,473,946.17</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,884,590.00	31,805,586.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,596,458.00	16,262,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,575,068.10	116,405,460.17
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>220,119,162.52</b>	<b>103,695,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>219,117,900.00</b>	<b>103,695,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,064,000.00	82,852,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,020,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	75,033,100.00	268,302.30
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	20,574,397.70
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,001,262.52</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,001,262.52	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,034,693,024.68</b>	<b>297,663,440.10</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>3,160,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	3,160,000.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>2,034,693,024.68</b>	<b>300,823,440.10</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,697,812,400.00</b>	<b>1,942,046,948.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>6,042,748.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>6,042,748.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>6,042,748.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,892,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	150,648.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,697,812,400.00</b>	<b>1,936,004,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,356,592,400.00</b>	<b>1,772,981,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,356,592,400.00	1,772,981,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>136,353,900.00</b>	<b>0.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>204,866,100.00</b>	<b>163,022,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,866,100.00	163,022,300.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,608,187,073.51</b>	<b>1,735,640,342.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,608,187,073.51</b>	<b>1,735,640,342.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,389,173,910.99</b>	<b>1,630,839,142.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>985,876,868.48</b>	<b>1,156,454,912.52</b>
210101	Үндсэн цалин	655,009,435.50	787,109,412.71
210102	Нэмэгдэл	252,525,290.27	306,929,550.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,182,000.00	4,652,000.00
210104	Урамшуулал	59,160,142.71	57,763,948.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>123,713,780.51</b>	<b>144,709,400.77</b>
210201	Тэтгэврийн даатгал	85,339,436.93	101,105,493.41
210202	Тэтгэмжийн даатгал	10,039,933.84	11,886,675.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,907,626.88	9,280,540.57
210204	Ажилгүйдлийн даатгал	1,856,980.31	1,950,548.66
210205	Эрүүл мэндийн даатгал	18,569,802.55	20,486,142.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>139,936,041.00</b>	<b>153,722,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,341,960.00	18,134,600.00
210302	Түлш, халаалт	128,594,081.00	130,337,700.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	5,250,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>72,650,021.00</b>	<b>100,105,263.50</b>
210502	Хоол, хүнс	72,650,021.00	100,105,263.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,500,000.00</b>	<b>9,300,000.00</b>
210604	Урсгал засвар	14,500,000.00	9,300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,583,400.00</b>	<b>10,345,200.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,844,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,583,400.00	8,500,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,913,800.00</b>	<b>56,202,066.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,139,900.00	40,169,166.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,773,900.00	16,032,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>219,013,162.52</b>	<b>104,801,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>218,011,900.00</b>	<b>104,801,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,958,000.00	83,958,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	20,842,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,001,262.52</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,001,262.52	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>89,625,326.49</b>	<b>206,406,605.21</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>42,197,000.00</b>	<b>51,076,770.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>42,197,000.00</b>	<b>51,076,770.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>42,197,000.00</b>	<b>51,076,770.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,197,000.00	51,076,770.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-42,197,000.00</b>	<b>-51,076,770.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>47,428,326.49</b>	<b>155,329,835.21</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	47,428,326.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,428,326.49	202,758,161.70

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	549,958,766.20	1,383,146,401.26	-1,933,105,167.46	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	-1,933,105,167.46	0.00
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,034,693,024.68	2,034,693,024.68
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	101,587,857.22	2,034,693,024.68
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	101,587,857.22	2,034,693,024.68
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	101,587,857.22	2,034,693,024.68
8	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	300,823,440.10	300,823,440.10
9	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	549,958,766.20	1,383,146,401.26	402,411,297.32	2,335,516,464.78

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,828,222,900.00</b>	<b>1,623,694,812.79</b>	<b>204,528,087.21</b>	<b>89.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,828,222,900.00</b>	<b>1,623,694,812.79</b>	<b>204,528,087.21</b>	<b>89.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,707,644,000.00</b>	<b>1,518,893,612.79</b>	<b>188,750,387.21</b>	<b>89.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,313,354,600.00</b>	<b>1,156,454,912.52</b>	<b>156,899,687.48</b>	<b>88.0</b>
210101	Үндсэн цалин	886,361,200.00	787,109,412.71	99,251,787.29	89.0
210102	Нэмэгдэл	354,812,200.00	306,929,550.84	47,882,649.16	86.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	4,652,000.00	-4,652,000.00	
210104	Урамшуулал	72,181,200.00	57,763,948.97	14,417,251.03	80.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>164,169,500.00</b>	<b>144,709,400.77</b>	<b>19,460,099.23</b>	<b>88.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	111,635,400.00	101,105,493.41	10,529,906.59	90.6
210202	Тэтгэмжийн даатгал	13,133,600.00	11,886,675.83	1,246,924.17	90.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,506,800.00	9,280,540.57	1,226,259.43	88.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,626,700.00	1,950,548.66	676,151.34	74.2
210205	Эрүүл мэндийн даатгал	26,267,000.00	20,486,142.30	5,780,857.70	78.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>104,973,000.00</b>	<b>100,105,263.50</b>	<b>4,867,736.50</b>	<b>95.3</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00	0.00	
210502	Хоол, хүнс	104,973,000.00	100,105,263.50	4,867,736.50	95.4
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,730,000.00</b>	<b>10,345,200.00</b>	<b>7,384,800.00</b>	<b>58.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,041,400.00	1,844,500.00	5,196,900.00	26.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,688,600.00	8,500,700.00	2,187,900.00	79.5
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>107,416,900.00</b>	<b>107,278,836.00</b>	<b>138,064.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,384,000.00	91,245,936.00	138,064.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,032,900.00	16,032,900.00	0.00	
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>120,578,900.00</b>	<b>104,801,200.00</b>	<b>15,777,700.00</b>	<b>87.0</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>120,578,900.00</b>	<b>104,801,200.00</b>	<b>15,777,700.00</b>	<b>87.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	99,736,200.00	83,958,500.00	15,777,700.00	84.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,842,700.00	20,842,700.00	0.00	100.0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,828,222,900.00</b>	<b>1,779,024,648.00</b>	<b>49,198,252.00</b>	<b>97.3</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,772,981,900.00</b>	<b>1,772,981,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,772,981,900.00	1,772,981,900.00	0.00	100.0
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>55,241,000.00</b>	<b>6,042,748.00</b>	<b>49,198,252.00</b>	<b>11.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,041,400.00	5,892,100.00	1,149,300.00	-360,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,700.00	150,648.00	52.00	360,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	48,048,900.00	0.00	48,048,900.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	47,428,326.49	-47,428,326.49	47,428,326.49
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	202,758,161.70	-202,758,161.70	202,758,161.70

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль нь 65 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Тус байгууллага нь үйл ажиллагаандаа*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 88,1 хувьтай үнэлэгдсэн.

2023 оны 11 дүгээр сарын 1 өдөр Сумын хяналт шалгалт үнэлгээний хорооны шалгалтаар 87,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 326,941.7 мянган төгрөгөөр буюу 16% хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	47,428.3	202,758.1	155,329.8
Авлага	360.0	0	
Урьдчилгаа			
Бараа материал	165,195.3	179,549.3	14,354.0
Үндсэн хөрөнгө	1,822,815.3	1,980,433.3	157,618.0
Нийт хөрөнгө	<b>2,035,799.0</b>	<b>2,362,740.7</b>	<b>326,941.7</b>
Өр төлбөр	1,106.0	27,224.3	26,118.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,034,693.0	2,335,516.4	300.823.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>2,035,799.0</b>	<b>2,362,740.7</b>	<b>326,941.7</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 155,329.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь /орон тоо хэмнэж ажилласан/ үндсэн цалин, нэмэгдэл зэргийг хэмнэснээс мөнгөн хөрөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл байхгүй байна. Урьд оны авлагыг тайлант хугацаанд бүрэн барагдуулсан.

Бараа материал дансны үлдэгдэл 14,354.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд улсад 3-р түвшинд үнэлэгдэн урамшуулал авсан нь бичиг хэргийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 157,618.0 мянган төгрөгөөр өссөн нь: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн дотуур байрны гал тогооны дээврийн засварыг 57,200.0 мянган төгрөгөөр, БШУГ-аас багш бүр компьютер хөтөлбөрөөр 31,300.0 мянган төгрөгийн 31 ширхэг зөөврийн компьютер, улсын төсвийн хөрөнгөөр 45,600.0 мянган төгрөгөөр багш бүрд 43 ширхэг таблет, дөрвөн ширхэг хичээлийн том самбарыг 5,400.0 мянган төгрөгөөр, арга зүйн ном 0.4 мянган төгрөгөөр тус тус орлого авсан мөн элэгдлээ нөхсөн эд хөрөнгийг дахин үнэлсний зөрүү 187,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,772,981.9 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 163,022.3 мянган төгрөг нийт зарлагыг 1,786,717.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,786,717.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,786.700.0 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,786.700.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,786.700.0 мянган төгрөг буюу 103,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 16,487.4 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалинг 8,019.8 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалинг 1,586.9 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71802-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	4,275.4	4,246.8	28.6	99.3%
2	80312-Сургалт семинар	2,137.7	2,068.0	69.7	96.7%
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	4,275.4	4,275.4	0	100%
4	81801-Үдийн цай хөтөлбөр	99,115.8	83,958.5	15,777.7	84.1%
5	81806- Дотуур байрны үйлчилгээ	28,389.7	24,831.2	3,558.4	87.4%
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	44,590.0	44,590.0	0	100%
7	81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	9,619.7	9,619.7	0	100%
8	81827- Бичиг үсгийн боловсрол олгох	2,415.0	459.1	1,955.9	19%
9	81834- Боловсролын стандарт	1,181,734.7	1,058,178.2	123,556.4	89.5%
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	278,478.3	256,016.3	22,461.9	91.9%

11	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.6	150.6	0	100%
12	81848- Сурах бичгийн түрээс	7,041.4	5,532.1	1,509.3	78.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80226	2023-12-31	Байр ашиглалтын үйлчилгээ	99.3%	4,275.4	4,246.8
2	71802-80312	2023-12-31	Сургалт семинар	96.7%	2,137.7	2,068.0
3	71802-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	100%	4,275.4	4,275.4
4	71802-81801	2023-12-31	Үдийн цай хөтөлбөр	84.1%	99,115.8	83,958.5
5	71802-81806	2023-12-31	Дотуур байрны үйлчилгээ	95.0%	146,339.9	139,114.0
6	71802-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	44,590.0	44,590.0
7	71802-81823	2023-12-31	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	100%	9,619.7	9,619.7
8	71802-81827	2023-12-31	Бичиг үсгийн боловсрол олгох	19%	2,415.0	459.1
9	71802-81834	2023-12-31	Болосролын стандарт	91.1%	1,181,734.7	1,077,351.7
10	71802-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	91.9%	278,478.3	256,016.3
11	71802-81844	2023-12-31	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	100%	150.6	150.6

12	71802-81848	2023-12-31	Сурах бичгийн түрээс	78.5%	7,041.4	5,532.1
----	-------------	------------	----------------------	-------	---------	---------

Бичиг үсгийн боловсрол олгох арга хэмжээ нь хангалтгүй болсон нь сургалтад хамрагдах ирц муугаас нөлөөлсөн. Сурах бичгийн түрээс арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сурах бичиг түрээслэх сурагчид бага байсан нь нөлөөлсөн.

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Аймгийн Боловсролын газраас тендер шалгаруулсан газруудаас шууд худалдан авалт хийсэн. Үүнд: Эрхэм Ундраа ХХК-с 100,420.1 мянган төгрөгийн хүнсний материал, Галтбадрах ХХК-с хүнсний ногоо, Авдрантын өгөөж ХХК-с 8,200.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг тус тус нийлүүлсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,650,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 33,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26,400.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 156,900.0 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 4,868.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>	4	12,340.1	4	12,340.1	100%
<b>Албан шаардлага</b>	1		1		100%
<b>Зөвлөмж</b>	3	440.7	3	440.7	100%
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>12,780.8</b>		<b>12,780.8</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын сургууль нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,870.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 7,870.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

#### 5.2 Албан шаардлага

#### 5.3 Зөвлөмж

##### 1. Зардлын данстай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Дотуур байрны хүүхдийн хоолны орц нормыг хэрэгжүүлэн ажиллаагүйн улмаас 6,875.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02 өдрийн А\166, А\556, 222 тоот хамтарсан тушаалын заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Цаашид дээрх тушаалд дурдсан хоолны орц нормыг баримтлан ажиллахыг ахлах тогооч мөрдөж, нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.

##### 2. Зардлын данстай холбоотой асуудал

Тус байгууллага нь 994.5 мянган төгрөгийн 117м цахилгааны утсыг анхан шатны баримтгүйгээр бараа материалын зарцуулалтын тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотуур байрны хүүхдийн хоолны орц нормыг баримтлан ажиллаагүй	1	6,875.7					1	6,875.7				
Бараа материалын тайланд 117м цахилгааны утсыг хаана зарцуулсныг шаардах хуудсанд дэлгэрэнгүй бичиж тэмдэглээгүй	1	994.5					1	994.5				
Дүн	2	7,870.2					2	7,870.2				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)